

## ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 08 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 08 дугаар сарын 31

Зуунмод

### **Нэг. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын алба:**

Энэ сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит 11 дүгээр хуралдаан 2020 оны 08-р сарын 13-ний өдөр хуралдлаа.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн XI Хуралдаанаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит 11 дүгээр хуралдаан 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж 7 асуудал хэлэлцэж 4 тогтоол батлаж, хуралдааны тэмдэглэлээр 3 үүрэг өгөв.

Үүнд:-

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 18 дугаар Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудал батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 18 дугаар хуралдааныг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хуралдааны танхимд хуралдуулж хуралдаанаар 3 асуудал хэлэлцэхээр тогтов.

2. Аймгийн 2020 оны төсвийн 2-р улирлын гүйцэтгэлийг хэлэлцээд аймгийн төсвийн хоёрдугаар улирлын гүйцэтгэл, коронавируст халдвар \COVID-19\-ын цар тахлаас эдийн засаг, төсвийн орлогын бүрдэлтэд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд дүн шинжилгээ хийж төсвийн орлогын төлөвлөгөөг сум бүр, нэр төрлөөр биелүүлэх, зардлын батлагдсан хэмжээг чанд мөрдөх талаар хийж буй ажлыг үргэлжлүүлж, шаардлагатай арга хэмжээ шуурхай авч, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, татварын өр барагдуулах талаар хийж буй ажлыг эрчимжүүлж, өр бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, орлогын байдалд нийцүүлэн өр барагдуулах талаар гэрээ хэлцэл хийж, биелэлтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, газрын бүртгэлийн цахим системийг бүрэн нэвтрүүлж эзэмшин, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг төлбөрт бүрэн хамруулж, хураан барагдуулах, газрын төлбөрийг 60, 40 хувиар аймаг, сумын төсөвт хуваарилан төвлөрүүлэх цахим программыг бүх сумдад яаралтай нэвтрүүлэх, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын газрын төлбөр тогтоосон эрхийн актыг судлан үзэж арга зүйн зөвөлгөөгөөр хангаж, шаардлагатай арга хэмжээ авч, аймгийн 2020 оны төсвийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогчид даалгав.

3. Аймгийн 2020 оны хөрөнгө оруулалт, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны явцыг хэлэлцээд аймгийн хэмжээнд 2020 онд улс, орон нутаг, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар нийт 82 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 95.1 хувь буюу 78-ыг нь зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлсэн бөгөөд, 8 дугаар сарын 10-ны байдлаар нийт хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт 50 хувийн биелэлттэй байна. Цаашид хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын явцыг эрчимжүүлж, цаг агаар хүйтрэхээс өмнө, төлөвлөсөн хугацаанд нь дуусгах арга хэмжээ авч, барилга байгууламжийг батлагдсан зураг төсөл, стандарт нормын дагуу чанартай гүйцэтгүүлэхэд онцгой анхаарч, хяналт шалгалтыг холбогдох дүрэм журмын дагуу хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Коронавируст халдвар \COVID-19\-ын цар тахлын улмаас хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэх эх үүсвэр хумигдаж болзошгүй байгааг анхаарч, энэ онд хийхээр төлөвлөж, хөрөнгийн эх үүсвэр нь төсөвт тусгагдсан ажлуудыг аль болох царцааж зогсоохгүй хийж гүйцэтгүүлэх, гэрээт хугацаанд нь ашиглалтад оруулах шаардлагатай байгааг тэмдэглээд Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ зэрэг холбогдох агентлаг, аж ахуйн нэгжүүдийн ажлын уялдааг хангаж, тус тусын хүлээсэн үүрийг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллах, улс, орон нутаг, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар энэ онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ, барилга угсралтын ажлыг батлагдсан нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгүүлэх, ажлын явц удааширсан тухай бүр шалтгааныг тогтоож, ажил эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах, Барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн хяналт, үе шатны хяналтыг сайжруулж ажлын дутагдал, гологдлыг цаг алдалгүй шуурхай засуулах арга хэмжээ авч байх, гүйцэтгэгчээр гэрээнд заасан ажлыг хугацаанд нь чанартай хийлгэж хүлээн авах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, алдаа дутагдал гаргасан, ажлаа чанаргүй гүйцэтгэсэн, түүнийг хүлээн авсан зэрэг зөрчил гаргасан албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээний холбогдох заалтууд болон зохих хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллах, захиалагч байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж буй “Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ыг өргөтгөн бэхжүүлж, орон тоог нэмэгдүүлэх, баг бүрэлдэхүүнийг чадавхжуулах, тус аж ахуйн нэгжийг зураг төсөв хийх тусгай зөвшөөрөлтэй болгох асуудлыг судлан энэ оны 9 дүгээр сард

багтаан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, орон нутагт хийгдэх барилга, бүтээн байгуулалтын ажлуудын зураг төсвийг өмнөх онд бэлэн болгож хэвших арга хэмжээнүүдийг авч улс, орон нутаг, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтийг хангахыг аймгийн Засаг даргын орлогчид даалгав.

4. Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн 2021 оны төсвийн төсөл, уг төслийг боловсруулсан тухай асуудлыг хэлэлцээд аймгийн 2021 оны төсвийн төслийг дэмжиж, Сангийн яам, бусад холбогдох яамдад уламжлав.

Төсвийн төслийг холбогдох яамдаар хянуулж, нэгтгүүлэхэд шаардагдах судалгаа, тооцоо, ялангуяа төсвийн зардал, батлагдсан хязгаарыг 6.4 тэрбум төгрөгөөр давж буй шалтгааныг тодорхойлох, тухайлбал зохих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон шинээр ашиглалтад орж байгаа барилга байгууламжийн ашиглалттай холбогдон нэмэгдэж буй зардлын тооцоо, судалгааг нарийвчлан гаргаж, шаардлагатай эрх зүйн актыг нягтлан бүрдүүлж төсвийн төслийг хянуулан нэгтгүүлэх, Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас эдийн засаг, төсвийн орлого бүрдэлтэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг харгалзан хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлж, тэвчиж болох зардлыг бууруулах асуудлыг төсөвт тусгах, аймгийн 2021 оны төсвийн төслийг холбогдох яамдаар хянуулсан тоо, хэмжээг үндэслэн сум, аж ахуйн нэгж, байгууллагаар хийсэн төсвийн орлого, зарлагын тооцоог төрөл нэг бүрээр нягтлан үзэж орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах асуудлыг эцэслэн тооцох, ялангуяа, шинээр ашиглалтад орох барилга байгууламжийн ашиглалттай холбогдон нэмэгдэх хөрөнгийг зардлын төрөл нэг бүрээр хянан үзэж энэ оноос мөрдөгдсөн Татварын болон Улсын бүртгэлийн багц хуулийг бүрэн хэрэгжүүлж татварын бааз суурийг өргөтгөн тэлж төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар хийх ажлыг оновчтой тодорхойлж, тооцоо судалгааг нарийвчлан хийх, газрын төлбөрийн орлогын төлөвлөж буй хэмжээг хангахын тулд газрын бүртгэлийн цахим системийг бүрэн нэвтрүүлж эзэмших, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын газрын төлбөр тогтоосон эрхийн актыг судлан үзэж арга зүйн зөвлөгөөгөөр хангах, эзэмшил, ашиглалтад байгаа газрыг төлбөрт бүрэн хамруулж, хураан барагдуулах талаар авах арга хэмжээг тодорхойлж төсвийн талаар гаргах шийдвэрт тусгах, төрийн албаны хүний нөөц, шилжилт хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санд суурилсан төрийн албан хаагчдын цалин хөлсний төлөвлөлт, санхүүжилтийн системийг бүрэн нэвтрүүлэх, эрүүл мэнд, байгаль орчны салбарт нэвтрүүлэх төсвийн төлөвлөлтийн шинэ аргачлал, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарт туршин нэвтрүүлэх жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар хийх ажлыг төсөвт тусгах, Засгийн газрын 2015 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын нормативыг тогтоох аргачлал”, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны хамтарсан 192/А243 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын дагуу сум бүрийн хог хаягдлын хураамжийг тогтоон, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн мөрдөх ажил хэт удааширч байгаад дүгнэлт хийж шаардлагатай арга хэмжээ авах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн орон нутгийн өмчийг худалдан борлуулах талаар гаргасан хэрэгжээгүй байгаа шийдвэрийн жагсаалтыг шинэчлэн гаргаж өөрчлөх, хэвээр мөрдүүлэх асуудлыг шийдвэрлэж холбогдох арга хэмжээ авч, 2021 оны төсөвт орон нутгийн өмч худалдаж, борлуулсны орлогыг бодитой тусгах, “Хөгжлийн түүчээ-Төв аймаг” аймгийн хөгжлийн хэтийн зорилтын 2 дугаар шатанд хийхээр тусгагдсан арга хэмжээ, аймгийн эдийн засаг, нийгмийн салбаруудын хөгжлийг тодорхойлсон бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоог нарийвчлан хийж “Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгуулах ажлыг зохион байгуулж, төсвийн төслийг нягтлан боловсруулахыг аймгийн Засаг даргын орлогчид даалгав.

5. Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан зохих үр дүнд хүргэж 96.66 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Аймгийн хэмжээнд биеийн тамирын 41 хамтлаг үйл ажиллагаа явуулж спортын 23 холбоотой хамтран ажиллаж улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнүүдийг зохион явуулж, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмад настны гэсэн ангилалаар болон үндэсний спортын төрлүүдээр зохион байгуулж давхардсан тоогоор 71.1 мянган хүн хамруулсан байна. Төлөвлөгөө хэрэгжүүлэх хугацаанд тив, дэлхий, олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 24 төрлөөр оролцож 1707 медаль хүртэж, тамирчдын дундаас олон улсын хэмжээний мастер 4, спортын мастер 19, спортын дэд мастер 20, зэрэгтэй тамирчин 2207, улсын шүүгч 4 шинээр төрөн гарчээ. Аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнд 2016-2020 онд хөл бөмбөг, сагсан бөмбөг, софт теннис, волейболын талбай, гүйлт, алхалт, дугуйн 500 м-ийн асфалтан зам, шагайн харвааны асар, үндэсний сурын талбай зэргийг орон нутгийн хөрөнгө оруулалтын 636,2 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр байгуулж ашиглалтад оруулсан нь биеийн тамир спортыг хөгжүүлэхэд

чухал хувь нэмэр оруулсан байна. Мөн Олон улсын хөл бөмбөгийн холбооны дэмжлэгээр 850 мянган долларын хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн олон улсын стандартын талбай, Баянцогт, Эрдэнэсант, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Алтанбулаг сумдад соёл, спортын төв, Цээл, Эрдэнэ сумдад ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, Баянхангай, Аргалант, Лүн суманд спорт заалыг тус тус ашиглалтад оруулжээ.

Зуунмод суманд 640 хүүхдийн багтаамжтай спортын төрөлжсөн сургалттай сургуулийн ажлын гүйцэтгэл 50-ийн биелэлттэй байна. Мөн спортын хэрэглэл материалаар хангах зорилгоор 20.0 сая төгрөгийн жүдо, боксын сургалт дасгалжуулалтад шаардагдах хэрэглэл материал, 15.0 сая төгрөгийн чөлөөт бөхийн дэвжээ, 14.4 сая төгрөгийн цана, тэшүүрийн хувцас хэрэглэл, 8.2 сая төгрөгийн шатрын танхим, нийт 62.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж спортын хэрэглэл материалын хангамжийг сайжруулж ажилласан байна.

“Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөө”-г зорилт, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэнийг тэмдэглээд Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөөний хэрэгжилт 96.66 хувийн биелэлттэй байх тул “Үр дүнтэй” гэж дүгнэв.

“Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид нийтийн биеийн тамир, их спортын талаар дэвшүүлэх зорилт, арга хэмжээг тодорхойлж, “Нийтийн биеийн тамир-Бүх нийтийн үйл хэрэг” уриан дор хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулж батлуулан, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогчид даалгалаа.

6. Зуунмод сумын төвөөс Манзушир хийдийн чиглэлд хатуу хучилттай авто зам барьж буй аж ахуйн нэгжид уг замд зориулж хайрга олборлох зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Зуунмод-Манзушир хийд чиглэлийн 7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэж буй “Ялгуусан” ХХК-д, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ыг жишиг болгон зөвхөн барьж буй авто замдаа зориулан хайрга, дайрга олборлох зөвшөөрөл олгох арга хэмжээ авах, Зуунмод-Манзушир хийд чиглэлийн авто замын барилгын ажилд шаардлагатай хайрга, дайрга олборлох талбайн байршлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоож, хайрга, дайрганы борлуулалтын үнэлгээг тогтоон, төлбөрийг зохих сумын төсөвт төвлөрүүлэх, олборлосон талбайн нөхөн сэргээлтийг журмын дагуу хийлгэх, цаашид орон нутгийн чанартай хатуу хучилттай авто зам барих ажил өргөжих төлөвтэй байгааг харгалзан дээр дурдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”, бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн орон нутгийн авто зам барьж буй аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах журам боловсруулан энэ онд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж мөрдөхийг аймгийн Засаг даргын орлогчид даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

7.Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд “Гавъяат жүжигчин цол”-оор 1, “Аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол”-оор 1, “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 2, “Алтан гадас одон”-оор 40, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 15 иргэдийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

2020 оны 8-р сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 20 албан бичиг ирснийг бүртгэн аймгийн ИТХ-ын дарга болон нарийн бичгийн даргад танилцуулан хариу өгөх шаардлагатай 3 бичгийн хариуг өгч ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргад хандсан Баянхангай сумын иргэнээс “Газар хүссэн тухай” өргөдөл ирснийг бүртгэн авч 08-р сарын 26-ны өдрийн 242 тоот албан бичгээр тухайн иргэнд болон Баянхангай сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 08-р сарын 26-ны өдрийн 241 тоот албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас аймгийн Засаг дарга болон холбогдох албан байгууллагад 28 бичиг гарган хүргүүлжээ.

*Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:*

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах ажилд зориулж Хьюндай соната-8 маркийн гурван автомашиныг аймгийн Цагдаагийн газарт гардуулан өглөө. Уг автомашины шинэчлэлийн санхүүжилтийг аймгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн бөгөөд тус арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, аймгийн Засаг даргын орлогч Д.Мөнхбаатар нар оролцлоо. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд:-

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос аймгийн ИТХ-ын нэмэлт дансанд сумдын дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу хуваарилагдсан 80.000.000 төгрөгийг нэхэмжлэгч Г.Лхамсүрэн, С.Гомбо нарын дансанд шилжүүлж нөхөх олговрын тайланг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисст хүргүүлжээ.

Аймгийн ИТХ-ын ээлжит 18 дугаар хуралдааны тов тогтсонтой холбогдуулан аймгийн ИТХ-ын Ажлын алба Хурлын хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

### **Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:**

*Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:*

“Хөгжлийн түүчээ- Төв аймаг 2024”, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 4 жилийн өссөн дүнгээр тооцон танилцуулга, мэдээлэл бэлтгэн ХШҮДАХ-т хүргүүлэв.

Төрийн албаны тусгай шалгалтуудыг зохион байгууллаа Төрийн захирааны удирдах албан тушаалд 6, гүйцэтгэх албан тушаалд 12 ажлын байр нөхөгдөв.

Засгийн газрын 1111 төсвөөс 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 33 өргөдөл гомдол хуваарилагдан ирсний 25 нь шийдвэрлэгдэн 8 шийдвэрлэх шатандаа байна. Аймгийн Засаг даргын 2017 оны “аймгийн төрийн байгууллага, албан тушаалтан иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу сар бүрийн эхэнд зохион байгуулагддаг “Иргэдтэй уулзах цаг”-ийг 08 дугаар сарын 03-ны өдөр Зуунмод сумын 6 багт зохион байгуулж 18 иргэний 30 санал хүсэлт, талархлыг хүлээн авч шийдвэрлэж байна.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхайг 08 дугаар сарын 10, 24-ний өдрүүдэд 2 удаа зохион байгуулж нийт 19 үүрэг даалгавар өгөгдсөн байна. 08 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн шуурхайн хэрэгжилт 78.88%-тай, 08 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн шуурхайн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

*Гадаад харилцаа:*

БНСУ-ын Гангвон муж, БНСУ-ын Пёнтаек хот, Япон улсын Изүмисано хот, Япон улсын Тоттори мужийн захирагч нарт Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж. Батжаргал Улсын Их Хурлын Гишүүнээр сонгогдсонд баяр хүргэж, амжилт хүссэн захидлыг ирүүлсэнд хариу талархал илэрхийлсэн албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн.

NEAR Зүүн хойд Азийн Нутгийн Захиргааны Холбооны Хэрэг эрхлэх газраас “Дэлхийн цэвэр агаарын өдөрт зориулан онлайн хурал”-д холбооны гишүүн орнуудын засаг дарга нарыг урьж оролцуулах тухай албан бичиг ирүүлсэн. Манай аймгийн Засаг дарга оролцох боломжгүй тухайгаа мэдэгдсэн.

Аймгийн шууд харилцаат Япон улсын Тоттори мужид болох төрийн албан хаагчийн богино хугацааны танилцах дадлагад Борнуур сумын иргэн Алтан-Онц дадлагажихаар шалгарсан. Дадлага 2020 оны 2-р сард эхлэхээр төлөвлөгдсөн байсан хэдий ч хэдий ч шинэ төрлийн Коронавирусээс шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшилсон. Дадлага онлайн хэлбэрээр зохион байгуулагдах талаар Тоттори мужийн Гадаад харилцааны газартай санал солилцож байна.

Япон улсын Тоттори муж болон Төв аймгийн хооронд сүүлийн жилүүдэд хүүхэд залуусын харилцаа арга хэмжээ хэрэгжиж байгаа. Өнгөрсөн жил Тоттори мужийн ахлах сургуулийн 4 сурагч багшийн хамт Хүмүүн цогцолбох ахлах сургуульд зочилж, Япон хэлний ангийн сурагчидтай харилцаа хамтын ажиллагааны арга хэмжээнд оролцсон. Энэ жил шинэ төрлийн Коронавирусээс шалтгаалан хүүхэд залуусын харилцаа арга хэмжээний хүрээнд цахим уулзалт зохион байгуулах тухай судлагдаж байна.

БНСУ-ын Пёнктаек хоттой хамтран ажиллах ажлын хүрээнд 400.0 сая вонны хөрөнгө оруулалтаар аймгийн Нийтийн номын сангийн шинэчлэл засвар хийх төслийг хамтарч хэрэгжүүлэн 2 тал тогтмол харилцан ажиллаж байна. Одоогийн байдлаар ажлын гүйцэтгэл 70 гаруй хувьтай үргэлжилж байна. БНСУ-ын Пёнктаек хотоос анхны санхүүжилт олгосон.

*Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:*

2020 оны 8 дугаар сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг 5870 иргэнд, өдөрт дунджаар 250-300 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, Сүлд, Live телевизүүдтэй, контент хуваах хэлбэрээр ТВ5, ТВ9 телевизүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Мөн Аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа 8 дугаар сард аймгийн веб сайтад 13, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд 35 мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ.

Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 4-н дугаарт 8 мэдээ мэдээлэл бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар 11 мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор 33 удаа цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй

утсанд 5 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар хугацаа болоогүй 5 гомдол байна.

Мөн тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны “Хур” системийг нэвтрүүлж 9 байгууллагын 56 төрлийн лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байгаа бөгөөд 8 сард нийт 23 төрлийн 511 лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилжээ.

### ***Мэргэжлийн хяналтын газар:***

#### ***1. Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын чиглэлээр:***

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны шалгалтын төлөвлөгөө болон 01/96 тоот удирдамж, Төв аймгийн МХГ-ын даргын 19/35 тоот удирдамж, Төв аймгийн Засаг даргын А/447 тоот захирамжийн дагуу Төв аймагт үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгаж, үнэлгээ дүгнэлт өгөх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төв аймгийн Засаг даргын А/447 тоот захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг 5 чиглэлд бүх суманд ажиллалаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтуяагаар ахлуулан боловсролын, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, хүнсний чанар, стандартын, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид болон БСУГ, ЭМГ-ын мэргэжилтнүүдийн баг хамтран ажиллав. Уг шалгалтыг 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 08 сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Шалгалтад аймгийн 27 сумын ерөнхий боловсролын 31, сургуулийн өмнөх боловсролын 41 байгууллагын нийт 117 объект хамрагдав.

Боловсролын байгууллагуудын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, эдэлбэр газрын тохижилт, ногоон байгууламж, цардсан талбай, биеийн тамир тоглоомын талбайг тохижуулсан байдал, сургууль, цэцэрлэгийн унд ахуйн хэрэгцээний усны чанар, аюулгүй байдал, багшийн хүрэлцээ хангамж, сургалтад хэрэглэх гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамж, хамран сургах хүүхдийн тоо, хамрагдалтын хувь, анги дүүргэлтийн урьдчилсан төлөв байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах нөхцөл боломж бүрдсэн эсэх, элсэлтийн үйл ажиллагаа, хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгасан.

Сургуулийн өмнөх байгууллага нийт 48 хамрагдахаас 41 цэцэрлэг хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 3-5 насны 5073 хүүхэд, үүнээс 5 настай 1865 хүүхэд 2020-2021 оны хичээлийн жилд хамрагдан 211 бүлэгт 209 багш ажиллаж, нэг бүлэгт 20-25 хүүхэд байхаар бэлтгэл ажлаа хангасан байна.

Ерөнхий боловсролын 31 сургуульд 17529 суралцагч суралцаж, 1-р ангид 2015 сурагч шинээр элсэн орж, дотуур байранд 2352 хүүхэд сууж, түүний дотор 6 настай 124 сурагч суухаар мэдээ гарсан байна.

Шалгалтын дүнг аймгийн аймгийн Засаг даргад танилцуулан аймгийн МХГ-ын Улсын ахлах байцаагчийн албан даалгавар гаргаж, үүрэг чиглэл сумын Засаг дарга, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн шалгалтаар ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт улсын байцаагчийн хамтарсан 5 албан шаардлага, 6 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

#### ***2. Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:***

*Төлөвлөгөөт хяналт шалгалт:*

Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/118, 19/128 дугаартай удирдамжаар Сэргэлэн, Баян, Баяндэлгэр, Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулж буй 22 объектод шалгалт хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахаар 49 заалт бүхий 19 албан шаардлага хүргүүлж ажилласан.

*Төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ:*

Байгаль орчны хяналтын чиглэлээр: Газрын даргын 19/119, 19/129 дугаартай удирдамжаар Сэргэлэн, Баян, Баяндэлгэр, Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулж буй 24 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Үйл ажиллагаа явуулж буй объектуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын байцаагчийн 49 заалт бүхий 15 зөвлөмж хүргүүлж ажилласан.

*Төлөвлөгөөт бус шалгалт*

Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр: Нөхөн сэргээлт 2020 ерөнхий арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020.07.10-ны өдрийн А/389 дүгээр Захирамжаар байгуулагдсан МХГ, БОАЖГ, ГХБХБГ, ЦГ-ын дарга нараар ахлуулсан 4 ажлын хэсэг хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон 23 сумын нутагт уул уурхайн үйдвэрлэл эрхлэгч 50 гаруй ААНэгж, байгууллага, бичил уурхайн нөхөрлөлийн үйл ажиллагаанд нөхөн сэргээлтийн арга хэмжээг эрчимжүүлэх нэмэгдүүлэх, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор хяналт шалгалт хийгдсэн. Шалгалтаар 308,23 га талбайд техникийн, 179,29 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгэсэн. Ашигт малтмалын ашиглалт, олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дагуу хийгээгүй 6 аж ахуйн нэгж, 11 бичил уурхайн нөхөрлөлд зохих журам, аргачлалын дагуу нөхөн сэргээлтийг хийж нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр: Аймгийн Поркурорын газрын 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн хамтран ажиллах тухай 1/1181 дугаартай албан хүсэлтийн дагуу Төв аймгийн Зуунмод суманд аймгийн инженерийн шугам сүлжээ бүхий газар баригдсан, баригдаж буй барилга, хашааны байшин, инженерийн шугам сүлжээний ажилуудыг Зуунмод сумын хөгжилийн Ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж олгогдсон эсэх, газар өмчлөгч, эзэмшигч иргэн аж ахуй нэгж байгууллагын газар ашиглалтын байдлыг газрын кадастрын мэдээллийн санг google map-н зурагтай давхцуулж зөрчилтэй иргэн аж ахуй нэгж байгууллагад шалгалт хийсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчил арилгах тухай аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлж ажилласан.

Барилга эхлэх зөвшөөрөлгүйгээр барилга барьж байсан иргэний үйл ажиллагааг актаар түр зогсоосон.

#### **Бусад хяналт:**

Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/14 дугаар урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Төв аймгийн Заамар, Сэргэлэн, Баян сумдын нутаг Нөхөн сэргээлт нэрээр ашигт малтмал олборлосон 2 бичил уурхай эрхлэгч, 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож, Төв аймаг дахь цагдаагийн газарт шилжүүлсэн.

1 аж ахуйн нэгж, 1 бичил уурхайн нөхөрлөлд ашигт малтмал хууль бусаар олборлосны улмаас байгаль орчинд учруулсан нийт 9,176,027 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн. Зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчиж үйл ажиллагаа явуулсан 2 ААН, 2 нөхөрлөлд нийт 14000000 төгрөгийн арга хэмжээ авч Төв аймгийн прокурорын газар хянуулж ажилласан.

Барилга техникийн хяналтын чиглэлээр: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/97 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Зуунмод суманд баригдаж байгаа барилгуудад харилцаа холбооны хяналтын улсын байцаагчтай хамтарсан шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага-3, түр зогсоох акт-2 үйлдсэн.

**3. Сорилтын нэгдсэн лаборатори:** Эрүүл ахуйн нян судлалын лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 105 дээжинд 325 үзүүлэлт (гурил гурилан бүтээгдэхүүний 3 сорьцонд 15, сүүн бүтээгдэхүүний 1 сорьцонд 6, махан бүтээгдэхүүний 2 сорьцонд 8, хоолны 7 сорьцонд 28, ариун материалын 8 сорьцонд 8, ундны усны 74 сорьцонд 222, хөрсний 8 сорьцонд 32, бохир усны 2 сорьцонд 6) үзүүлэлтээр эрүүл ахуйн нян судлалын шинжилгээг хийж ажилласан байна. **Үүнээс:** ундны 8 сорьц 8 үзүүлэлт эерэг стандартын шаардлага хангаагүй дүнтэй гарсан.

Лабораторийн итгэмжлэлд бэлтгэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Эрүүл ахуйн нян судлалын лабораторийн 12 ажлын хуудас, 16 бүртгэлийн маягт, хими хор судлалын лабораторийн 24 ажлын хуудас, 20 бүртгэлийн маягт, ургамлын эрүүл ахуй хорио цээрийн лабораторийн 8 ажлын хуудас, 4 бүртгэл маягтыг Газрын даргын тушаалаар батлуулахад бэлэн болсон.

2. Итгэмжлэлийн газрын баримт бичгийн үнэлгээгээр илэрсэн үл тохирлыг залруулан Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн.
3. Хөгц мөөгөнцрийн лабораторид хөгц мөөгөнцрийн төрлөөр үзүүлэн самбар хийсэн.
4. Хими хор судлалын лабораторийн татах шүүгээ, ФЭКийг засварлуулж ажилд оруулсан.
5. Нийт лабораторийн 63 нэр төрлийн багаж тоног төхөөрөмж, шилэн хэмжих хэрэгслийг баталгаажуулалтанд хамруулж шалгалт тохируулгын гэрчилгээг авсан.
6. Нэгж лабораторийн захиалгын дагуу шаардлагатай эм урвалж, шил сав, туслах материалыг гэрээт байгууллагуудад захиалан авсан.
7. Мөн лабораторийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй бүрэн хамруулж ажиллалаа.

**Онцгой байдлын газрын хүрээнд:**

Төв аймгийн Онцгой байдлын газар			
№	Төрөл	Мэдээний агуулга	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ
1.	Усны ослын дуудлага	Төв аймгийн Өндөрширээт сумын Баянтуулбагийн "Модон гүүр" гэдэг газарт/сумын төвөөс хойдзүгт 12 км-т, аймгийн төвөөс баруун урд зүгт 197 км-т/ Улаанбаатар хотоос Төв аймгийн Өндөрширээт суманд загасчилахаар ирсэн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны 5 дугаар гудамжны 73 тоотод оршин суугч иргэнЦ.Лхагвасүрэн /26 настай, эрэгтэй/ "Туул" голын усанд осолдсон гэсэн дуудлагыг 2020.08.09-нийөдрийн 12:38 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга хошууч Г.Ганхөлөгөөр ахлуулсан 4 алба хаагч, 1 автомашин, 1 завьтай <b>13:22</b> цагт ангийн байрлалаас хөдөлсөн. 17:40 цагт дуудлагын газарт очиж, <b>17:46</b> цагт эрлийн ажиллагааг эхлүүлсэн. <b>2020.08.13-ны</b> өдөр "Үндэсний аврах бригад"-аас 8 алба хаагч 1 автомашин, 1 завьтай, Төв аймгийн Онцгой байдлын газраас 6 алба хаагч, 1 автомашин, 1 завьтай, Ар гэрээс 15 хүн, 7 автомашинтай. Нийт 29 хүн, 9 автомашин, 2 завьтай ажиллаж <b>11:50</b> цагт иргэн Ц.Лхагвасүрэнгийн цогцсыг анх осолдсон газраас гэдэг газраас зүүн хойд зүгт 28 км-т Уянга багийн нутаг "Таван нуурын булан" / <b>өргөрөг 47°59'24.0" уртраг 105°96'00"</b> / гэдэг газарт "Туул" голын усны мандал дээр хөвж байсныг олж, Өндөрширээт сумын цагдаагийн хэсгийн цагдаагийн дэд ахлагч Б.Өлзийдаваад <b>13:30 цагт</b> шилжүүлэн өгсөн.
2.	Усны ослын дуудлага	Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн "Туулын гүүр" гэдэг газарт / Аймгийн төвөөс баруун хойд зүгт 226 км-т, сумын төвөөс баруун зүгт 12 км-т, / Улаанбаатар хотын харъяат иргэн Д.Содтөр /38 настай эрэгтэй/ "Туул" голын усанд орох гээд байна гэсэн дуудлагыг 13:40 цагт Заамар сумын Цагдаагийн хэлтсийн жижүүр ахмад Б.Жаргалсайхан хүлээн авч 2020.08.13-ны өдрийн 17:55 цагт Төв аймгийн Онцгой байдлын газар хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын эрэн хайх, аврах бүлгийн дарга, дэслэгч М.Жадамбаар ахлуулсан 6 алба хаагч, 1 автомашин, 1 завьтай, тус сумын Цагдаагийн хэсгийн 6 алба хаагч, 1 автомашин, ар гэрээс 7 хүн, 1 автомашинтай. Нийт 19 хүн , 3 автомашин, 1 завьтай ажиллаж 2020.08.17- ны өдрийн <b>17:03</b> цагт иргэн Д.Содтөрийн цогцсыг анх осолдсон газраас баруун зүгт 25 км-т Уянга багийн нутаг "Тул харайдаг" гэдэг газарт "Туул" голын эрэг дээр гарсан байсныг олж, Заамар сумын цагдаагийн хэсгийн Мөрдөн байцаах тасгийн дарга хошууч Ч.Дагвадоржид <b>17:40 цагт</b> шилжүүлэн өгсөн.

3.	Эрэн хайх, аврах ажиллагаа	Төв аймгийн Батсүмбэр сумын Сөгнөгөр багийн /сумын төвөөс зүүн зүгт 12км-т, аймгийн төвөөс хойд зүгт 122 км-т/ "Монос" амралтын газарт амарч байсан Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны "Нарны замын" 136Б байрны 1403 тоотод оршин суугч иргэн Э.Ууганжаргал /41 настай, эрэгтэй/ 2020.09.04-ний 23:00 цагаас хойш сураггүй болсон тухай дуудлагыг 2020.09.05-ны өдрийн 18:38 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч дэслэгч Н.Хуягбаатараар ахлуулсан 3 алба хаагч 1 нохой, 1 завь, 1 автомашинтай, Цагдаагийн 1 алба хаагч, Ар гэрийн 17 хүн, 2 автомашин. Нийт 22 хүн, 3 автомашин, 1 завь, 1 эрэлч нохойтой эрлийн ажиллагааг явуулж 2020.09.07-ны өдрийн 10:30 цагт иргэн Э.Ууганжаргалын цогцсыг анх осол болсон газраас баруун зүгт 3 км-т Баянгол багийн нутаг "Мөнгөн хазаар" гэдэг газарт "Сөгнөгөр" голын усанд хөвж байсныг олж, Баянчандмань сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч, хошууч Ж.Батмөнхөд /99106618/ 11:00 цагт шилжүүлэн өгсөн.
1.	Объектын гал түймэр	Төв аймгийн Зуунмод сумын Дэнж багийн 1 дүгээр байрны 3 тоотод оршин суух иргэн Л.Жаргалсайханы модон амбаар шатаж байна гэсэн дуудлагыг 2020.08.02-ны өдрийн 00:55 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн 6 алба хаагч 1 автомашинтай 2 километр замыг туулан очиход иргэн Л.Жаргалсайханы 4х3 хэмжээтэй модон амбаар шатаж байсныг 600 литр ус зарцуулж бүрэн унтраасан. Уг гал түймэрт гэмтэж бэртсэн хүн байхгүй.
2.	Объектын гал түймэр	Төв аймгийн Батсүмбэр сумын Сөгнөгөр багийн "Үйлдвэрийн" 1 дүгээр гудамжны 3 тоотод оршин суугч иргэн Ц.Булганы эзэмшлийн 4х8 хэмжээтэй автомашины блокон граш шатаж байна гэсэн дуудлагыг 2020.08.28-ний өдрийн 18:50 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 75 дугаар ангийн 3 алба хаагч, 1 автомашинтай 1 километр замыг туулан 18:53 цагт голомтод хүрэлцэн очиж 500 литр ус зарцуулан 20 минут ажиллаж 19:12 цагт унтраасан. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.
3.	Объектын гал түймэр	Төв аймгийн Зуунмод сумын Энхтайван багийн 13 дугаар гудамжны 1 тоотод иргэн Б.Мижиддоржийн өвлийн байшин шатаж байна гэсэн дуудлага 2020.09.04-ны өдрийн 12:48 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн салааны захирагч дэслэгч Б.Бямбанямаар ахлуулсан 6 алба хаагч 1 автомашинтай 12:48 цагт ангийн байрлалаас гарч хаягийн дагуу 12:51 цагт хүрэлцэн очиход цахилгааны утаснаас гал алдаж хайрцагтай өвлийн хувцас, хөрөгчийн нэг талын булан хэсгээс хайрагдсан байсан. Уг дуудлага нь зөрчлийн дуудлага байсныг илрүүлээд 13:21 цагт ангийн байрлалд буцаж ирсэн.
4.	Объектын гал түймэр	Төв аймгийн Батсүмбэр сумын Мандал багийн "Суврага" 5 дугаар гудамжинд Төв аймгийн Батсүмбэр сумын "Төмөр замын" 39 дугаар гудамжны 2 тоотод оршин суугч Т.Баянмөнхийн эзэмшлийн 61-10 УБН улсын дугаартай "Ниссан тина" загварын автомашин шатаж байна гэсэн дуудлагыг 2020.09.06-ны өдрийн 16:13 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 75 дугаар ангийн 3 алба хаагч, 1 автомашинтай 2 километр замыг туулан 16:17 цагт голомтод хүрэлцэн очиж 2 тонн ус зарцуулан 28 минут ажиллаж 16:45 цагт унтраасан. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.
5.	Объектын гал түймэр	Төв аймгийн Эрдэнэсант сумын Улаанхудаг багийн нутаг "2 дугаар хороо" гэдэг газарт / Төв аймгийн төвөөс баруун баруун зүгт 220 км-т/ /Сумын төвийн баруун хойд талдаа 1 км-т/ иргэн Г.Дэжидийн иж бүрэн тавилгатай, 5 ханатай гэр 2020.08.04-ны өдрийн 12:21 цагт бүрэн шатсан тухай мэдээлэл өгсөн.	Тус сумын цагдаа ахлах ахлагч Б.Саруулмөнх 12:25 цагт дуудлагын газар очиж үзлэх хийхээр 1 автомашинтай явсан.
6.	Объектын гал түймэр /мэдээлэл/	Төв аймгийн Борнуур сумын Нарт багийн "Шавартай хад" гэдэг газарт /сумын төвөөс баруун хойд зүгт 12 км-т/ 4х5 хэмжээтэй модон байшин шатаж байна гэсэн дуудлагыг 2020.09.06-ний өдрийн 14:14 цагт хүлээн авсан.	Тус сумын Байгаль орчны улсын хяналтын байцаагч Б.Мөнхзулаар ахлуулсан 4 иргэн, 1 автомашинтай 14:53 цагт хүрэлцэн очиход бүрэн шатсан. Хэсгийн төлөөлөгч цагдаагийн дэслэгч Г.Ган-Эрдэнэд хүлээлгэн өгсөн. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.



7.	Объектын гал түймэр /мэдээ/	Төв аймгийн Баянчандмань сумын Замт багийн /Сумын төвдөө, аймгийн төвөөс баруун хойд зүгт 111 км-т/ Бичигтийн 7 дугаар гудамжны 505 тоотод оршин суугч иргэн Н.Эрхэмбаярийн эзэмшлийн 5 ханатай монгол гэр, эд хогшлын хамт бүрэн шатсан гэсэн мэдээллийг 2020.09.08-ний өдрийн 04:32 цагт хүлээн авсан.	Тус сумын 30 иргэн, 8 автомашинтай ажиллаж унтраасан. Уг гал түймэрт бэртэж гэмтсэн хүн байхгүй.
1.	Аврах ажиллагаа /Голын ус шавар/	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт байрлах "Голомт" банкны 15 ажилчин 2 автомашинтай 2020.07.30-ны өдөр Улаанбаатар хотоос Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах "Хагийн хар нуур" руу аялалд гарсан. /Сумын төвөөс зүүн зүгт 47 км-т/ байрлах Баянтуул багийн нутаг "Тэмээн хүзүү" гэдэг газарт автомашинаа орхиж цааш Баянтуул багийн нутаг /Сумын төвөөс зүүн хойд зүгт 110 км-т/ "Хагийн хар нуур" руу явганаар явсан. 2020.08.03-ны өдөр "Хагийн хар нуурнаас буцаж яваад Баянтуул багийн нутаг Хан хэнтий дархан цаазад газрын хяналтын цэг "Шар булгийн ам" гэх газарт "Туул гол" -ын усанд боогдсон. 2020.08.01-ний өдөр Улаанбаатар хотоос "Голомт" банкны 7 ажилтан 1 автомашинтай эхэнд явсан 15 ажилтанаа тосхоор яваад сураггүй болсон шаварт суусан байх магадлалтай гэсэн дуудлагын 2020.08.04-ны өдрийн 03:00 цагт хүлээн авсан.	Тус аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын дарга ахлах дэслэгч З.Отгонзулаар ахлуулсан 4 алба хаагч, 1 завь, 1 автомашинтай 09:10 цагт дуудлагын газар руу ангийн байрлалаас хөдөлсөн. 09:00 цагт "Голомт банкны" ажилтан н.Бат-Эрдэнэтэй /98993315/ дугаарын утсаар холбогдоход 2020.08.03-нд "Шар булгийн ам"-нд бууж ирсэн. Тосож ирэхээр болсон 7 ажилтантайгаа холбогдож чадаагүй. "Шар булгийн ам"-наас 500 метрийн зайд модонд "Жи мобайл"-ын сүлжээний антентай тэндээс холбоонд орж байна гэсэн мэдээ өгсөн. 10:30 цагт Эрэн хайх, аврах салбарын дарга, ахлах дэслэгч З.Отгонзултай /86015656/ утсаар холбогдоход "Голомт" банкны ажилчин Б.Баатартай Налайх дүүрэгт уулзаад хамт дуудлагын газар руу явж байна гэж мэдэгдсэн.

### **Гурав. Хууль, эрх зүйн хэлтсийн хүрээнд:**

#### **Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 08 дугаар сарын дугаарыг “Зөрчлийн тухай хууль”-ийн сэдвээр бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 30 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 33 иргэн болон сум, байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлэв.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 6 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 5 шүүх хуралдаанд оролцсон.

Аймгийн нутаг дэвсгэрт буддын шашны хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн Баянцагаан, Батсүмбэр, Эрдэнэсант сумын 3 иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан үзээд Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өргөн барилаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн ажлын төлөвлөгөөнд “Гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Засаг даргын Зөвлөлийн 08 дугаар сарын хурлаар хэлэлцүүлж, холбогдох үүрэг чиглэлийг сум, байгууллагад өгч ажиллалаа.

Аймгийн ГХУСА33-өөс санаачилан Төв телевизтэй хамтран “Төвшин амгалан” цуврал нэвтрүүлгийн 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн дугаараар Шүүхийн шинжилгээний алба, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн холбогдох албан тушаалтнуудыг оролцуулж, аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэлээ.

Авилгатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан авлигын эсрэг сурталчилгааны материалыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио, телевизээр дамжуулан 38 сурталчилгааны шторкийг өдөр

бүр 3 удаагийн давтамжтайгаар хүргэж, 27 сумын Засаг даргын Тамгын газрын “Иргэний танхим”-аар болон төрийн байгууллагуудын цахим хуудсуудаар хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Ажлын Албанаас Ажлын хэсэг Төв аймагт 2020 оны 08 дугаар сарын 05-наас 3 хоногийн хугацаатай ажиллаж, 05, 07 дугаар сард өгсөн үүргийн хэрэгжилтийг шалгаж 6 байгууллага, 7 суманд очиж танилцлаа.

Архивын тасгийн чиглэлээр:

Төрийн архивын үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор үйл ажиллагааг дэмжиж орон нутгийн төсвөөс 21.5 сая төгрөгөөр техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчилж, суурилуулсан.

Төрийн Архивын тасгаас 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газар болон Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, 2019 онд өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Төрийн архивын эх баримтаас 128 иргэний хүсэлтээр 504 хуулбар хувь, 93 лавлагаа, 158 хөмрөгийн 922 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлж, 1.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

5 хөмрөгийн 126 хадгаламжийн нэгжийн 6427 хуудас баримтын 23255 хүний нэр, 5744 заалтын тоо, 5744 тушаалын тоог мэдээллийн програмд шивж, 5 хөмрөгийн 126 хадгаламжийн нэгжийн 5603 хуудас баримт скайнердаж, 5744 заалтын 6427 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбон цахим бааз үүсгэж, 3 хөмрөгийн 121 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ, техник боловсруулалтыг хийснээр архивын баримтын цахимжуулалт 65.0 хувьд хүрсэн.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

1.Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд цахим санд нийт 57027 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10.247, газар өмчлөх эрхийн 46.780 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 21.258.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 127.1 сая төгрөг, үл хөдлөх худалдан борлуулсны 118.3 сая төгрөг тэмдэгтийн хураамжаас 3.6 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Энэ сард нийт 159 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 75 нэмэлт өөрчлөлт, шинээр 123 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 4, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 27 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 1 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 1 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 8.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 8 дугаар сарын байдлаар нийт 560 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 хэргээр буюу -4,5 хувиар буурсан, гэмт хэргийн илрүүлэлт 41,5 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,3 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гаргасан 19, шүүхээр баривчлагдсан 24, албадан саатуулагдсан 1, ар гэрт нь хүлээлгэн өгсөн 7, нийт 51 хүний биед болон эрүүл мэндийн үзлэг хийсэн.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаагүй. Гудамж талбай олон нийтийн газарт 4 алба хаагч 7 цагаар 840 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж 250 аж ахуйн нэгж байгууллагын харуул манааг шалгаж, ахуйн хүрээний 105 дуудлагад явж зөрчил гаргасан 100 иргэнийг 870.0 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

Шүүх хурлын 1, 2, 3-р танхимуудад 1680 оролцогчтой Эрүүгийн хэргийн 192, Иргэний хэргийн 130, Захиргааны 14, Хянан магадлангийн-13, нийт 349 шүүх хуралдаанд журам сахиулж, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 84 жолоочийг илрүүлж, 61 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 23 иргэнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5191 жолоочийг 158.0 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 48 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

**Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:**

Энэ сард Криминалистикийн шинжилгээ-121, Нийт хийсэн магадлан шинжилгээ-135, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-443, гарын мөрийн санг баяжуулсан-169, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 541 гаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:**

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
08-р сар	321	257	29	549	260	289	47.3%
	4335531.9	2156806.3	1211039.4	5281298.8	1138228.2	4143070.6	

**Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:**

**Хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр**

**Газар тариалангийн талаар:**

Ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын бэлтгэл ажлын явцын мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

Аймгийн 2020 оны намрын ургацын балас тогтоох ажлын хэсгийн Засаг даргын 2020 оны А/421 тоот захирамжаар газар тариалан бүхий 16 суманд 2 ажлын хэсэг ажиллалаа. Ургацын урьдчилсан балансаар аймгийн хэмжээнд:

Үр тариа -87.9 мян.тн  
Тосны ургамал -7.2 мян. тн,  
Таримал тэжээл -51.0 мян. тн  
Хүнсний ногоо -22.7 мян. тн,  
Төмс -155.9 мян. тн хураан авах урьдчилсан тооцоо гарлаа.

Намрын ургац хураалтад 1518 ажиллах хүч шаардлагатай 6 сумын 53 иргэн, аж ахуй нэгжийн судалгааг ХХААХҮЯам, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Батлан хамгаалах яам болон холбогдох газруудад уламжилж, “АРВИН УРГАЦ –АЖЛЫН БАЙР” аян өрнүүлэн ажиллаж байна. Намрын ургац хураалтын штабыг Засаг даргын 08 сарын 24 өдрийн А/450 дугаар захирамжаар байгуулан штабын хурлыг зохион байгуулж, ургацын хураалтын зөвлөгөөн, дутагдаж буй ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэх, аяныг идэвхижүүлэх, хил залгаа аймаг, сумдтай хамтарч ажиллахаар шийдвэрлэлээ.

Ургац хураалтад ажиллах техник тоног төхөөрөмж, зоорь, агуулах, үтрэмийн бэлэн байдал 87 хувьтай хангаж, 710 орчим ХАА-н техник тоног төхөөрөмж, 15000 орчим хүн 18-21 хоног ажиллана. Төмс хүнсний ногоо, таримал тэжээл үйлдвэрлэгчдийн борлуулалт, хадгалалтанд анхаарч Зоорийн аж ахуй эрхлэгчидтэй 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

**Мал аж ахуйн талаар:**

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд малчин, мал бүхий иргэд 138.2 мянган тн хадлан, 36.1 мянган тн гар тэжээл бэлтгэхээс өөрийн сумаас хадлан бэлтгэх бололцоотой Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянчандмань, Баянцогт, Борнуур Жаргалант, Мөнгөнморьт, Цээл, Угтаалцайдам, Сүмбэр сумд 1531.0 тн хадлан бэлтгээд байна.

Хадлангийн техникийн бэлэн байдал 82.0 хувьтай байгаа ба, 22 хадлангийн салаа 52 трактор, 148 бага оврын трактор, 166 автомашин, 138 гар хадуур, 148 морин хадуур, 23 чиргүүл, 399 хүн, 61 хаман боогч ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 26 суманд инженерийн хийцтэй 39 худаг шинээр гаргахаас, 32 худгийг сумдын ЗДТГазарт хүлээлгэн өглөө.

Ноосны урамшууллын анхан шатны материалыг хүлээн авч, программд оруулан, тулгалтын ажил хийгдэж байна.

### *Үйлдвэрлэл, үйлчилгээний талаар:*

“Мах, цагаан идээ, хүнсний ногоо -2020” үзэсгэлэн худалдааг Хөдөө аж ахуйн биржтэй хамтран Лавай, Зайсан хилл худалдааны төвүүдэд 08 дугаар сарын 29-ний өдрөөс 09 дүгээр сарын 11 ны өдөр хүртэл зохион байгуулах бэлтгэлийг хангалаа

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу хөнгөлөлттэй зээлийн I, II шатны шалгаруулалтад 17 аж ахуйн нэгжийн 1.9 тэр бум төгрөгийн төсөл шалгарч, дараагийн шатны нарийвчилсан шатны үнэлгээнд хамрагдахаар шийдвэрлэгдлээ.

Мерит төсөлтэй хамтран бизнес төвөлөлт, биенесийн харилцаа, албан бичиг төлөвлөх, маркетинг, зах зээлийн судалгаа хийх, борлуулалт нэмэгдүүлэх Модул-I сургалт зохион байгуулж, 8 сумын 25 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамрууллаа.

### *Малын эрүүл мэндийн чиглэлээр:*

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаар Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулж, вакцины нийлүүлэлт 100%, вакцинжуулалт 91.7 хувьтай явагдаж байна.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын А/344 тоот захирамжаар эхлүүлэн угаалгад 4604.1 мян.мал хамруулахаас 2804.1 мян.мал хамруулж 60.9 хувьтай, туулгалтад 938.4 мян.мал хамруулахаас 816.4 мян.мал хамруулж 86.9 хувьтай, боловсруулалтад 774.2 мян.мал хамруулахаас 658.2 мян.мал хамруулж 85 хувьтай тус тус хэрэгжиж байна.

Аймгийн хэмжээнд 881 хашаа хорооны 616,1 мян/м2, 988 худаг уст цэгийн 60,2 мян/м2, Бэлчээр-27.7 мян/м2, 84 агуулах зоорийн 44,1 мян/м2, 48 устгалын цэгийн 58.2 мян/м2 нийтийн эзэмшил зам талбайн 237,5 мян/м2, нийт 1043,8 мян/м2 талбайд халдваргүйтгэл хийж 82,5 хувьтай байна.

Мал эмнэлгийн цахим гэрчилгээг олгож одоогийн байдлаар 21412 гэрчилгээ олгогдож, 1647 дуудлагын дагуу үйлчилгээ үзүүлсэн.

Мал эмнэлгийн нэгдсэн системд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын асуулгын дагуу 85 нэгжийн мэдээллийг оруулаад байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 1173.4 мян.мал хамруулахаас 165.4 мян.мал хамруулж 14.1 хувьтай хэрэгжиж байна.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 2942 тээврийн хэрэгсэл, тэмээ 315, адуу 5872, үхэр 4086, хонь 40211, ямаа 20316 толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 1338,5 тн, арьс шир 125508 ширхэг, ноос 634 тн ноолуур 402,8 тн, дайвар-29,3 тн, цагаан идээ-1,4 тн бүтээгдэхүүний эрүүл ахуй, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийсэн. Зөрчилтэй тээврийн хэрэгсэл 58 явсныг хянан шалгаж тухай бүр нь арга хэмжээ авч ажиллалаа.

Лабораторийн шинжилгээнд ийлдэс судлалын 2450 дээжинд бруцеллёз, лейкоз, сүрьеэ өвчний тандах шинжилгээг хийхэд сөрөг, Нян судлалын 38 дээжинд цусан халдвар, ДХХ, Энтеробактериоз листериозийн шинжилгээ хийхэд сөрөг, Ариун цэврийн шинжилгээнд 25 худалдааны цэг, иргэнээс 56 мах, сүүний дээж авч антибиотекийн үлдэгдэл, бруцеллёзын шинжилгээ хийхэд бүгд сөрөг урвал үзүүлэв.

Аймгийн хэмжээнд 19355 хээлтүүлэгч малыг шинжилгээнд хамруулахаас өнөөдрийн байдлаар 9 сумын 2437 малыг хамруулж 12.5 хувьтай байна

### **Стандарт хэмжил зүйн чиглэлээр:**

#### *1.Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр:*

2020 оны 08 дугаар сарын байдлаар Зуунмод, Сэргэлэн, Батсүмбэр, Дэлгэрхаан сумдад ажиллан Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 12 бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулсан. Үүнд: Амралт жуулчны бааз-3, Худалдаа-5, Нийтийн хоол-4

Хэлтсийн орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөлийн хурал хуралдаж 10 бүтээгдэхүүн үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгохоор шийдвэрлэв.

Стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг 5 ААН, иргэнд хүргэлээ.

#### *2. Нээлттэй хаалганы өдөрлөг*

2020 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Төв аймгийн Дэлгэрхаан суманд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулал, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн харъяа агентлагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан хаагчид оролцов. Тус өдөрлөгөөр Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн зүгээс иргэд, ААН-дэд Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, холбогдох стандартын талаар мэдээлэл танилцуулга хийн бүтээгдэхүүн

үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулав. Мөн сумын иргэд, ААН-үүдийн санал хүсэлтийг сонсож тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэж өглөө. Нийт 10 иргэнд мэдээлэл, сурталчигааг хүргэсэн байна. Стандарт хэмжил зүйтэй холбоотой 3 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

### **3. Дотоод зохион байгуулалтын талаар:**

Өргөдөл, гомдол, саналын талаар:

Байгууллагад 11 албан бичиг ирснээс 5 хариутай албан бичгийг холбогдох мэргэжилтэнд шилжүүлэн хариуг хугацаанд өгч ажиллаа. Хугацаа хоцорсон болон сунгуулсан албан бичиг байхгүй болно. Хэлтсийн албан хаагчдын шуурхай 1, баталгаажуулалтын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаа. Хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөн хурлаас өгсөн үүрэг даалгаварт хяналт тавин ажиллаж байна.

2020 оны 8 дугаар сарын байдлаар хэлтэст 14 өргөдөл, хүсэлт ирснээс 12 нь тохирлын гэрчилгээ шинээр авах, сунгуулах, 2 нь хүний нөөцтэй холбоотой өргөдөл хүсэлт, байна. Ирсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллаа. 8 дугаар сарын байдлаар хэлтсийн хэмжээнд иргэд, ААН-ээс ямар нэг гомдол, санал ирээгүй байна.

*Мэдээ, мэдээллийн ил тод байдлын талаар:*

2020 оны 08 сарын байдлаар тус хэлтсийн үйл ажиллагааны талаарх 2 мэдээ мэдээллийг доорх олон нийтийн цахим сүлжээ ашиглан мэдээлсэн байна. Үүнд:

Төв аймгийн хэвлэл, мэдээллийн албаны пэйж хуудсаар – 1

Хэлтсийн пэйж хуудсаар – 2 мэдээ

Хэлтсийн [www.masm.to.gov.mn](http://www.masm.to.gov.mn)- 2 мэдээ

### **Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр:**

Аймгийн ТЕЗахирагчийн 2020 оны хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.khural.mn](http://www.khural.mn) сайт “Өдрийн сонин”-ны 2020.01.07-ны №003 (6369)-т “Монголын үнэн” сонины 2020.01.08-ны №003-т тус тус нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 39,678.8 сая төгрөгийн 103 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 36,780.1 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс өссөн дүнгээр 79 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу 28,140.9 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээнд захиалагч байгууллага гэрээ байгуулсан.

8-р сарын байдлаар тендерийн шатанд байгаа төсөл, арга хэмжээ

Тендер зарлагдсан төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2,504.2 сая төгрөгийн 1 ажил

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн 790.0 сая төгрөгийн 2 ажил

Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 255.0 сая төгрөгийн 1 ажил

Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 548.4 сая төгрөгийн 4 ажил

Аймгийн мал хамгаалах сангаас өвс худалдан авах 48.0 сая төгрөгийн 1 ажил

Үнэлгээний хорооноос захиалагч байгууллагуудад нийт гэрээ байгуулах дүгнэлт хүргүүлсэн төсөл, арга хэмжээ-гэрээ хийгдэхээр хүлээгдэж буй ажил

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,024.6 сая төгрөгийн 2 ажил

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцыг аймгийн ИТХТ-н хурлаар хэлэлцүүлж худалдан авах ажиллагааны явц 95.1 хувьтай, хөрөнгө оруулалтын ажлын явц 50%-тай байна.

### **Орон нутгийн өмчийн чиглэлээр:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 51 дүгээр тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэгдсэн Зуунмод мах боловсруулах үйлдвэрийн 2 дахь дуудлагын худалдааг зарлан явуулахад оролцогчгүй тул дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг 30%-иар бууруулж, 409,1 сая төгрөгөөр худалдахаар холбогдох хууль журмын дагуу материалыг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан батлуулахаар, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолын хэрэгжилтийн дагуу 3 н тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулж, автомашины төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэн ажиллаа.

### **Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

Барилга хот байгуулалтын яамны сайд, дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг сумын шинэчлэл төслийн хүрээнд 08 сарын 01-ний өдөр Төв аймагт ажиллаж сумын төвийн шинэчлэл төсөлд өмнө нь хамрагдаж байсан Лүн сум сумтай танилцаж төслийн үр дүн, төсөл хэрхэн хэрэгжсэн тухай, цаашид хэрэгжүүлэх ажил, тулгамдаж буй асуудлуудыг судалсан.

Мөн сумын төвийн шинэчлэл төслийг аймгийн хүн ам олоноор суурьшсан Борнуур, Батсүмбэр сумдад хэрэгжүүлэхээр сумдын одоогийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцан ажиллаж сумдын

инженерийн барилга байгууламж, өрхийн эдийн засгийн чадавхи, дэд бүтэцтэй танилцаж газар дээр нь дүн шинжилгээ хийж тус сумдыг сумын төвийн шинэчлэл төсөлд бүрэн хамрагдах боломжтой гэж үзсэн. Тус ажлын хүрээнд: Аймгийн сумдын одоо байгаа инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, авто зам, явган хүний зам талбайн тооцоо судалгааг гарган БХБЯ, БХТ-д хүргүүлсэн.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2020 онд 48 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаад байна. Энэ сард архитектур төлөвлөлтийн даалгавар 6 аж ахуйн нэгжид олголоо.

2020 онд 48 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 7 барилгын зураг төсөл зөвшөөрөлцсөн. Засгийн газрын 2018 оны 68, 171 тоот тогтоолын хүрээнд 2020 оны 61 барилга байгууламжийн эхлүүлэх зөвшөөрөл олгов. Энэ сард манайд 15 барилга байгууламжид барилга эхлүүлэх зөвшөөрөл олгогдсон байна.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хүрээнд нийт 6-н барилга байгууламжид комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулсан байна.

#### **Газрын харилцааны чиглэлээр:**

“Байгалийн гамшигт үзэгдэл, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Зуунмод сумын нутаг дэвсгэрт голын ай, сав дагуу оршин суудаг айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх, газрын байршлыг өөрчлөх санал боловсруулах” Аймгийн засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/380 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу Баянхошуу баг, Нацагдорж баг, Зүүндэлгэр багын үерт өртсөн айл өрхүүдийн зарим иргэдтэй газар дээр нь очиж ажиллан нарийвчилсан судалгааг гарган яаралтай шилжүүлэх шаардлагатай Баянхошуу багт 9, Нацагдорж 5-р баг 4 иргэн, газрын кадастр, Зүүндэлгэр 4-р багт 15 иргэний газрын кадастрыг хийж газрыг зааж баталгаажуулж өгсөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага болон тус газрын хооронд 2019 оны 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээнд заасан “Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд одоогийн байдлаар 4973 цэгийн үнэлж, мэдээллийг хадгалан ГЗГЗЗГазарт хүргүүлсэн.

“Нөхөн сэргээлт-2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн аймгийн Засаг даргын А/386 тоот захирамжийн дагуу салбар төлөвлөгөө гаргаж, 27 сумыг 4 бүс болгон хуваасан. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг нь 08 сарын 03-ны өдрөөс 08-р сарын 04-ний өдрийг дуустал 2 хоногийн хугацаанд Баян, Баянжаргалан, Баяндэлгэр, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад, 1-р ажлын хэсэгт Геодези зураг зүйн мэргэжилтэн Заамар сумдын нутаг дэвсгэрт байрлах уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдэж, хөндөгдсөн талбай, одоо олборлолт явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих зорилгоор 6 хоногт ажилласан.

#### **Газрын төлбөрийн чиглэлээр:**

Газрын төлбөр: 2020 оны 8 дугаар сарын байдлаар газрын төлбөрийн орлого 1,933,333.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,937,844.4 мянган төгрөгийг төвлөрүүлж 100.2%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 276,762.2 мянган төгрөг дутуу төлөлтөөс, 563069.4 мянган төгрөг дуудлага худалдаанаас төвлөрсөн. Аймгийн хэмжээнд 25 сумын 333 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс 14 сумын 229 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгуулсан. Төв аймгийн Дэлгэрхаан суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2020 оны 08 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсан. Нээлтэй хаалганы өдрөөр газар өмчлөл, өвөлжөө хаваржаа, кадастрын зураг хийлгэх, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулж нийт 23 иргэнд мэдээллийн сангын үйлчилгээ үзүүлсэн.

#### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:**

##### *Ойн бодлогын талаар:*

Лүн сумын сум дундын ойн анги БХНСАХЗардлаар Зуунмод голын цэцэрлэгт хүрээлэн “Ногоон паспорт-Ногоон төгөл” ойн зурвасыг өргөжүүлж, 1100 ширхэг навчит мод, гоёлын бут сөөг тарих ажлыг 8 дугаар сарын 2- 7 өдөр хийлээ.

2020 оны 08-р сарын 15-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн С.Эрдэнэцогт, МХГазрын улсын ахлах байцаагч Н. Ганбаяр, Батсүмбэр суман дахь сум дундын ойн ангийн дарга Ж. Гомбосүрэн, мэргэжилтэн Ц. Батбаяр, мэргэжилтэн Ш. Гантулга, нарын хамт 2020 оны 08 сарын 11 ны өдөр [zorig.mn](http://zorig.mn) цахим сайтад цацагдсан мэдээллийн дагуу, Батсүмбэр суманд ажиллаж Цогт-Өндөр 2-р баг Шатангийн Төгөлийн эх, Шарга морьтийн ар болон өвөр, Тэргэн даваа морин даваа зэрэг газруудад үндсээрээ булгарч хугарсан 327ш нойтон модонд гаргасан ойн ангийн дүгнэлтээр Батсүмбэр сумын засаг дарга А/415 тоот захирамж гарган цэвэрлэгээний ажил хийсэн

газарт, мөн Сөгнөгөр 3-р багийн нутаг дэвсгэр “Мань-уул хайрхан” ХХК, “Титэм-ой” ХХК, “Сод ногоон төгөл” ХХК-нуудын мод бэлтгэхээр ойн сангийн 97,160,161-дүгээр хэсэглэлд 42 га газарт талбай тусгаарлалт хийлгэн Сумын засаг даргын захирамж гарган мод бэлтгэх үйл ажиллагаа явуулсан газарт үзлэг шалгалтын ажлыг газар дээр нь явуулсан. Тухайн сайтад дурдагдсан тусгай хамгаалалтай газарт мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулсан, ургаа нойтон мод огтолсон, мод бэлтгэлийн талбай тусгаарласан газраас хэтэрч мод бэлтгэсэн гэж мэдээлсэн ноцтой зөрчилүүд илэрсэнгүй.

*Уул уурхай, хяналт шалгалтын талаар:*

Нөхөн сэргээлт -2020 арга хэмжээний хүрээнд 8сарын 3-8-ны хооронд Уул уурхай бүхий сумдад Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналт, Цагдаа, Газрын алба гэсэн 4 байгууллагы хамтарсан шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтын үр дүнд 176 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 308 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдлээ.

*Биологийн төрөл зүйлийн ажлын талаар:*

Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг хийлгэж, 2021-2025 оны менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын тендэр 2 удаа зарлан гүйцэтгэгч шалгаараагүй тул шууд гэрээ байгуулахаар болсон. 07сарын 31 нд Монгол орны хөтөн судлалын нийгэмлэгтэй гэрээ байгуулан судалгааны ажил сумдаар хийгдэж байна.

*Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын талаар:*

Аргалант,Архуст, Баян, Баян-Өнжүүл,Борнуур, Заамар, Өндөрширээт,Сүмбэр сумдын төвийн Ус түгээх цэг, усан сангуудад цахим төхөөрөмж суурилуулах ажлын гэрээг Баялаг говь ХХК- тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлэхээр боллоо.

Баяндэлгэр, Баянхангай, Зуунмод, Лүн, Сүмбэр сумдын төвийн “Ундны усны худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах” ажлын гэрээг Ирмүүн бармат ххк-тай шууд гэрээ байгуулан ажиллаж байна.

***Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:***

*Урьдчилан мэдээлэх талаар:*

Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайтад байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. Дотоод удирдлагын систем, И-мэйл хаяг, [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайт, TuvTsaguur page-д байршуулан хэрэглэгчдэд хүргэв. 08 дугаар сарын 12-нд нутгийн өмнөд хэсгээр, 13-нд зүүн хэсгээр их бороо орох тул гэнэтийн үер ус, нөөлөг салхины аюулаас сэрэмжтэй байхыг онцгойлон анхааруулсан мэдээг 12-48 цагийн өмнө [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайт, TuvTsaguur page-д, Дотоод удирдлагын системийн олон нийтийн цэсэнд байршуулан Зуунмод сумын 943 хэрэглэгч /малчид, ард иргэд/-ийн гар утсанд Багц мессежээр хүргэж үйлчиллээ.

*Байгаль орчны шинжилгээний лаборатори:*

Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Цаг уур, орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний хэлтсээс Агаарын чанарын ажиглалтыг 08 дугаар сарын 01-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр зогсоох чиглэл өгсөний дагуу зогсоосон. Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 08 дугаар сард Туул-Лүн, Шивэрт-Борнуур голын хяналт шинжилгээний цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны эрдэсжилтүүд 134-332 мг/мл байсан, голын ус органик бодисын болон эрдэс азотын бохирдолгүй цэвэр байсан.

*Ус судлалын салбар:*

Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2020 оны 08 дугаар сарын 21 -ны байдлаар усны түвшин Туул гол Туул-Алтанбулаг харуул 624 см, Туул-Лүн харуул 182 см, Туул-Заамар харуул 208 см, Хэрлэн гол Хэрлэн-Хонгон харуул 156 см, Хэрлэн-Мөнгөнморьт харуул 169 см, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 229 см, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуул 136 см тус тус байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Туул-Алтанбулаг харуул 24 см-ээр бага, 6-н усны харуулуудын усны түвшин 2-56 см-ээр их байна.

***Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:***

Улсын төсвийн 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-өнжүүл, Бүрэн, Өндөрширээт, Лүн, Сүмбэр, Алтанбулаг суманд 4 пургон, 2 УАЗ 469 автомашин, орон нутгийн 80.0 сая төгрөгийн санхүүжилтээр АНЭ-т унтуулгын аппарат тус тус хүлээлгэн өглөө.

Бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан аймгийн боловсролын салбарын удирдах ажилтны нэгдсэн сургалт, семинарыг 2020 оны

08 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Зуунмод хотод зохион байгуулж, 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилтоо тодорхойлж баталлаа.

Тус хугацаанд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр Жендэрийн үндэсний хороо болон Мерит төслөөс 2 удаагийн сургалт зохион байгуулагдлаа. Үүнд:

Мерит төслөөс 2020 оны 08 сарын 13-17-ны хооронд “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сургалт Сүхбаатар аймагт зохион байгуулагдаж Дорнод аймаг болон Төв аймгийн төлөөлөлүүд оролцлоо. Үүнд Төв аймгаас Нийгмийн бодлогын хэлтсийн дарга бөгөөд аймгийн жендэрийн салбар хорооны нарийн бичгийн дарга мөн жендэрийн мэргэжилтэн нар хамрагдаж бичил төсөл боловсруулан хэрэгжүүлэх үүрэг, чиглэл авч ажиллаж байна.

Жендэрийн үндэсний хорооноос 2020 оны 08 сарын 27- 28-ны өдрүүдэд Булган аймагт бүсийн сургалт зохион байгуулж оролцооны хяналт үнэлгээ, мэдээлэл харилцааны ур чадвар хөгжүүлэх чиглэлээр холбогдох мэргэжилтнүүд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж Төв аймгаас АЗДТГ-ын ХШУДАХ-ийн мэргэжилтэн, НҮХМОНХА-ын хэвлэлийн ажилтан, жендэрийн мэргэжилтэн, төрийн бус байгууллагын 4 төлөөлөл нийт 7 хүн сургалтад хамрагдаж чадавхжлаа.

2020 оны хичээлийн шинэ жилийг угтан аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцаж буй бүтэн өнчин 40 сурагчид аймгийн Засаг даргын баярын илгээлт, гарын бэлгийг хүргүүлж, хичээлийн шинэ жилийн бэлтгэлд зориулж тус бүр 80.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Бүх шатны сургалтын байгууллагын хичээлийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газартай хамтран Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэм сахиулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх 6 ажлын хэсэг 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрүүдэд 27 суманд ажиллалаа.

Аймгийн боловсролын тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайлан, танилцуулга, мэдээллийг бэлтгэн 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, ИТХ-ийн 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

#### ***Нийгмийн даатгалын хэлтэс:***

“Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж мэдээллийн баазад оруулсан 51 хувийн хэргийг шалгаж зөвлөмж өгч ажилласан.

МУ-ын Засгийн газрын 140-р тогтоолоор батлагдсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2020 оны 8 дугаар сарын 26-ны байдлаар 532 ААН-гийн 2859 даатгуулагчийг Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн ослын даатгалын зэрэг 4 сангийн 1160.5 сая төгрөг, 4040 сайн дурын даатгуулагчийн 1847.6 сая төгрөгийг шимтгэлээс бүрэн чөлөөлсөн байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд Татварын ерөнхий газраас ирүүлсэн үйл ажиллагаа нь доголдсон, орлого нь буурсан ААН-ийн жагсаалтад хамрагдсан 62 ААН-ийг хөнгөлөлтөд хамруулахаар шийдвэрлэснээс 45 ААН-ийн 305 даатгуулагчид 181 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн хэмжээнд 14840 тэтгэвэр авагчдад 5.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олголоо. ЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийн нэмэгдүүлэхэд баримтлах журмын дагуу нийт 1507 тэтгэвэр авагчдад 7.5 сая төгрөгийн нэмэгдэл олголоо.

Аймгийн хэмжээнд 16 архивын лавлагаа, тодорхойлолт-9 цахимаар 4 нийт 29 лавлагаа, тодорхойлолт гарган иргэд даатгуулагчдад өгч ажилласан.

Аймгийн хэмжээнд 130 даатгуулагч жирэмсэн амаржсаны тэтгэмж 201.4 сая, 120 даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 16.5 сая, 50 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж 105.5 сая, оршуулгын тэтгэмж 13 даатгуулагчийн 13 сая төгрөг нийт 336.4 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

#### ***Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:***

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, аймгийн Цагдаагийн газартай хамтарсан удирдамжийн дагуу Эрдэнэ, Борнуур, Баянчандмань сумдад насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд насанд хүрээгүй хүүхэд ажиллаж байгаа эсэх, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, хүүхдийг болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг 2020.08.06-07-ны өдрүүдэд зохион байгууллаа. Хяналт шалгалтаар 23 хүнсний дэлгүүр, 8 цайны газарт ажиллаж 4 төрлийн 315 ширхэг гарын авлага, санамж бичгийг тарааж ажилласан.



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран ажиллахаар 8 дугаар сарын 12-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Уулзалтад Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэд дарга Б.Халиун, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Д.Бадамцэцэг нар оролцож, харилцан мэдээлэл солилцож цаашид хоёр байгууллагын хамтран хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнүүдийн талаар хэлэлцсэн юм. Тухайлбал, Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүний гэр бүлийн харилцаа, залуучуудын хөгжил, хүүхэд, багачуудын хүмүүжил, төлөвшлийг анхаарч ажиллах талаар хамтарсан төлөвлөгөө боловсруулж ажиллахаар харилцан тохиролцсон уулзалт зохион байгуулсан.

“Нэг санаачлага-Нэг залуу” залуучуудын хөгжлийн сарын аяныг 08.01-ний өдрөөс 09.01-ний өдрийг хүртэл зохион байгуулж 9 төрлийн арга хэмжээнд 564 залуучуудыг хамруулан, цахим орчинд 2804 хандалт авсан байна. Аяны хүрээнд 016 дугаар бригадын 340 ажилтан албан хаагчдад “Эх оронч залуус” лекц, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Залуу гэр бүлийн “Андгай өргөх ёслол”, “Залуучууд хорт зуршлаас татгалзая” зөвлөмж, шинээр сайн дурын ажилтан бэлтгэх, бүртгэх ажилд 18 залуу, цахим номын сангийн 16 гишүүдийн дунд хэлэлцүүлэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн АХА тэмцээнд 46 залуучуудыг хамруулан сарын аяны хаалтын арга хэмжээг Зуунмод Цэцэрлэгт хүрээлэнд 120 залууг хамруулан зохион байгуулсан. Мөн 16 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч байгаа Баянчандмань сумын хүүхдийг Улаанбаатар дээд сургуульд 4 жил үнэ төлбөргүй сурах боломжоор хангасан.

Гэр бүлийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж байгаа өрхийн 1-р ангийн 46 сурагчдад дүрэмт хувцас, 181 хүүхдэд цүнх, хичээлийн хэрэгслийн тусламж дэмжлэг үзүүллээ.

#### ***Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:***

*Нийгмийн халамжийн чиглэлээр:*

*Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ*

2020 оны 8-р сарын байдлаар 1,759 иргэнд 504,068,870 төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1,015 иргэнд 92,582,740 төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 212 иргэнд 60,689,120 төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 234 ахмад настанд 35,067,934 төгрөгийн хөнгөлөлт тусламж, 49 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 3,808,500 төгрөгийн хөнгөлөлт тусламж, 51 алдар цолтой ахмад настанд 8,390,000 төгрөг, нийт 3,320 иргэнд 704,606,930 төгрөг олгосон байна.

*Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгийн талаар:*

ӨМНС-н өргөдөлийн тоо-16. Шийдвэрлэсэн-10. Судалж шалгаж байгаа-6 өргөдөл байна. Шинэ төрсөн 146 хүүхдийн мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. ӨМНСанд бүртгэлтэй 1 8700 өрхийн 27890 хүүхэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж байна. Судалгааны үр дүнгээр хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах 3 өрхийн 18 иргэнийг хүнс хөтөлбөрт хамруулан хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн.

*Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:*

*Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:*

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 17 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 3 ажил олгогч байгууллага, иргэнээс 23 сул чөлөөтэй ажлын байр, 9 иргэнийг ажилд зуучилсан, 3 шинэ ажлын байрны мэдээллийг мэдээллийн санд оруулж ажиллалаа. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах 15-н иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн.

*Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд:*

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 55 иргэнд Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн үйл ажиллагаа, ХЗЗ-2 маягтын дагуу ажил хайгч иргэдийг бүртгэж, нээлттэй ажлын байрны зарыг танилцуулж, 16 иргэнийг тохирох ажлын байранд зуучилан ажилласан.

*Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:*

Угтаалцайдам сумын ажил олоход хүндрэлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангасан Хишлэг, Чандмань дөл ХХКомпаниудад 8200,0 мян төгрөгийн урамшууллыг ХЭДСангаас олголоо. Нийтийг хамарсан ажлын хүрээнд Дэлгэрхаан сумын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж ажилгүй 15 иргэнд 4,2 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлсийг ХЭДСангаас олгосон.

*Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:*

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний талаарх мэдээллийг ТВ нэвтрүүлэг, веб хуудас, олон нийтийн сүлжээгээр олон нийтэд мэдээлж бүртгэлийг цахимаар явуулж ажилласан. Гарааны бизнес санаа хөгжүүлэх 3 хоногийн сургалтыг Зуунмод, Борнуур, Жаргалант, Батсүмбэр сумын 11 багийн 22 залуучуудад зохион байгуулсан. Үүнээс шалгарсан 7 багийн залуус хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж байна.

*Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:*

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэ, Өндөрширээт, Дэлгэрхаан, Эрдэнэсант сумын 10 өрхөд 47,0 сая төгрөгийн санхүүжилт олгож малжуулах төсөлд хамруулсан.

Эрдэнэ сумын 3 малчинд 13,0 сая

Өндөрширээт сумын 3 малчинд 15,0 сая

Дэлгэрхаан сумын 2 малчинд 10,0 сая

Эрдэнэсант сумын 2 айлд 9,0 сая төгрөгийн санхүүжилтийг ХЭДСангаас олгосон.

*Бусад*

Зуунмод сумын 40 өрхийн 50 хүүхдэд Холт олон улсын байгууллагаас хүүхэд тус бүрт сард 15\$-ийн тусламж үзүүлж байна.

Зуунмод сумын Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрт хяналт шалгалт хийж шалгуур үзүүлэлтэд заагдсан 10 нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ, чанарт хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

#### **Боловсрол, соёл, урлагийн газар:**

2020-2021 оны хичээлийн жилд аймгийн төвийн сургуулиудад 3 өдөр танхимаар, 2 өдөр онлайнар хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад анхаарах асуудлаар БШУЯ-аас баталсан тушаал, мөрдөх журам, баримт бичгүүдийг сургуулиудад хүргүүлж арга зүйн зөвлөмж өглөө.

БШУЯ-нд хичээлийн жилийн бэлтгэл хангах талаар хийж хээгжүүлсэн ажлын талаарх судалгаа мэдээллийг аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 31 сургуулиас авч нэгтгэн 2020 оны 8-р сарын 18,21,27-ны өдрүүдэд хүргүүллээ.

ЕБС, цэцэрлэгийн удирдах ажилтны сул ажлын байрны захиалгыг аймгийн Төв аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлд хүргүүллээ.

“2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажил анхаарах асуудал” сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 30 сургуулийн захирал, 43 сургалтын менежер, 42 цэцэрлэгийн эрхлэгч нарт зохион байгууллаа.

Боловсролын салбарын удирдах ажилтны семинар зохион байгуулж 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилтоо тодорхойллоо.

Боловсролын салбарын ажилтан ажиллагсдын шагналыг БШУЯ-ны мэдээллийн системд оруулах ажлыг зохион байгуулж байна.

Судлагдахуун бүрээр БМДИ-ээс зохион байгуулсан “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт онлайн сургалтад аймгийн төвийн 3 сургууль, Алтанбулаг, Лүн, Жаргалант, Сэргэлэн, Эрдэнэ сумдын ЕБС-ийн 233 багш нарыг хамрууллаа.

#### **Музей:**

Музейгээс 8-р сард 1083 иргэнд музейн үйлчилгээг үзүүлсэн. Үүнээс хүүхэд -408, том хүн-669, 1498000 төгрөгийн орлого төвлөрүүлж ажилласан. Нийт өссөн дүнгээр 2668500 төгрөгийн орлого төвлөрүүлж, 1957 иргэнд музейг үзүүлээд байна.

Монголын Динозавр Судлалын Хүрээлэнгийн нүүдлийн үзэсгэлэн 8-р сарын 14-ний өдөр Төв аймагт ирж орон нутгийн хүүхдүүдийг хамруулан сургалт зохион байгуулж, нүүдлийн үзэсгэлэнг иргэд, хүүхдэд үзүүллээ. Тус сургалтад 5-15 насны 51 хүүхдийг оролцуулж, нүүдлийн үзэсгэлэнг нийт 160 гаруй хүүхэд үзэж сонирхлоо.

Манзушир дахь Сэрүүн лаврин шашны музейн хашааг засварлаж, Байгалийн музейн болон гэрийн хаалгыг будах зэрэг засварын ажлыг байгууллагын албан хаагчид хийж гүйцэтгэлээ.

#### **Аймгийн БТСГазар:**

МУ-ын хошой мэргэн Доржийн Цэдэнсодномын алдрыг тэмдэглэх Өлзийт нуурын 22 дахь удаагийн тойром харваа 2020 оны 08-р сарын 01-02-ны өдрүүдэд Баянцагаан сумын нутагт зохион байгуулагдаж 21 багийн 168 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.Энэ удаагийн тойром харваанд МУУДМ 10, СУДМ 5, МУГМ 3, МУХМ 5, МУМ 10, аймгийн гоц мэргэн 35 оролцлоо.

Чөлөөт, үндэсний бөхийн шигшээ багийн тамирчдын зуны нэгдсэн бэлтгэл цугларалтыг 2020 оны 08-р сарын 03-ны өдрөөс 21 хоног Төв аймгийн Батсүмбэр суманд зохион байгуулж 52 тамирчин хамрууллаа.

Адуучин 2020 тэмцээнийг Төв аймгийн Лүн сумын “Өгөөмөр” багт 2020 оны 08 сарын 15-ны өдөр зохион байгуулж 72 адуучин хамрагдлаа.

Монголын анхны дугуйн лигийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 08 сарын 21, 22, 23-ны өдрүүдэд Төв аймгийн Алтанбулаг, Баян, Зуунмод сумын замд 3 өдөр зохиогдож Монголын шилдэг 27 тамирчин өрсөлдснөөс ОУХМ Т.Төгөлдөр дасгалжуулагчтай “CITIUS” баг тэргүүн байр, Бөөн гараа 105 км-н зай, ганцаарчилсан 25 км-н зайн аваргаар ОУХМ Б.Марал-Эрдэнэ энэ тэмцээний “Шилдэг залуу тамирчин”-аар Төв аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчин А.Хүслэн тодорлоо.

#### **Эрүүл мэндийн салбарын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 2020 оны 07 сарын байдлаар 663 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 29 тохиолдлоор өссөн ба 665 нярай бүртгэгдсэн байна. Нийт 190863 иргэнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 77535, амбулаторийн үзлэг 79827, идэвхитэй хяналтын 15836 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 11167 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, стационарт 8433 хүн эмчлэгдэн нийт 62131 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7,4 байна.

Халдварт өвчний сэжигтэй 8 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд: хачигт халдвар 1, энтеровирус 4, дезинтери 1, гэдэсний бусад бактерит өвчлөл 3 бүртгэгдсэн байна. Тархвар зүйн судалгааг хийж голомтын ариутгал, халдваргүйтгэл хийлээ. Хачигт халдварын 1 сорьцийн шинжилгээг ЗӨСҮТ-д хүргүүлсэн.

Батсүмбэр сумын Баянхангай, Баянбайгаль, ахмадын сувилал, ахмадын амралтын 1360 мкв талбайд, Аргалант сумын Налгар 520 мкв талбайд, Эрдэнэ сумын Тулгат амралтын газрын 210 мкв нийт 6 объектын 2090 мкв талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Төв аймгийн нутаг дэвсгэр дээр байрлах тусгаарлан ажиглах байранд нийт 151 иргэн 21 хоног тусгаарлагдсан, одоогоор 72 хүн ажиглалтад байна. Гэрийн тусгаарлалтад нийт 63 иргэн ажиглалтад гарснаас одоогоор 35 иргэн 11 сумын Эрүүл мэндийн төвийн хяналт ажиглалтад байна.

Орчны эрүүл мэндийн лабораторид Зуунмод сумын 6 цэцэрлэгийн ундны усны нийт 12 дээжид хими 98, нянгийн 18 үзүүлэлтээр сорил шинжилгээ гүйцэтгэлээ.

НЭМҮТ-ийн полиомиелитын /цочмог сул саажилтын тандалт/ лабораторид Зуунмод сумын 1-5 насны 30 хүүхдийн баасны сорьц цуглуулан хүргүүлсэн.

ДЭМБ, ЭМЯ, Геронтологийн үндэсний төвөөс улсын хэмжээнд зохион байгуулсан “Ахмад настныг гэрийн тусламж үйлчилгээнд хамруулах нь” сэдэвт төслийн үйл ажиллагааны нээлт, цахим хуралд холбогдох 5 албан хаагч хамрагдаж мэдээлэл авлаа.

2020-2021 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй уялдуулан нийт 27 суманд үйл ажиллагаа явуулж буй ЕБС, цэцэрлэгийн захирал, менежер, эрхлэгч, эмч нарт “Коронавируст халдвар, COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, цаашид хэрэгжүүлэх арга зам” сэдвээр сургалт хийв. Сургалтад нийт 145 хүн хамрагдаж, гарын авлага, зөвлөмжөөр хангасан.

Зуунмод сумын цэцэрлэгийн насны 700 гаруй хүүхдийг 6 төрлийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа.

Тарваган тахал өвчний оношилгоо, урьдчилан сэргийлэх сэдвээр 27 сумын Эрүүл мэндийн төвийн 84 эмч, эмнэлгийн ажилтанд цахим хурал зохион байгууллаа.

Томуугийн вакинд хамрагдах иргэдийн судалгааг гаргаж ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлжээ. Аймгийн хэмжээнд томуугийн вакцинд хамрагдах зорилтот бүлгийн 39100 иргэн байна.

“Салбарын хөгжилд хамтдаа” төслийн хүрээнд Улсын Нэгдүгээр Төв эмнэлэгтэй хамтран 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг зохион байгуулан Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн 17 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж үзлэгт нийт 110 үйлчлүүлэгч хамрагдсан бөгөөд нүд 7, уушги 25, дотоод шүүрэл 16, зүрх судас 21, бөөр 11, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо 5, эрэгтэйчүүдийн мэс засал 3, дүр оношилгоо 7, чих хамар хоолойн чиглэлээр 15 хүн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хамрагдаж, зөвлөгөө авсан.

2020 оны 8 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд Алтанбулаг, Заамар, Архурт, Баянжаргалан, Батсүмбэр сумдын боловсролын байгууллагын 398 багш ажилчдыг урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулсан.

### **Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:**

#### ***Төсвийн орлогын талаар:***

Орлогын төлөвлөгөө 7 дугаар сарын байдлаар орон нутаг 2499,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 2607,8 сая төгрөг төвлөрүүлж 104,3 хувьтай, 4,3 хувиар орлогын төлөвлөгөө биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 7660,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 8734,3 сая төгрөг төвлөрүүлж 114,0 хувьтай, 14,0 хувиар давуулан биелүүлсэн байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 1601,2 сая төгрөгөөр давж, 113,2 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Архурт, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Өндөрширээт, Сүмбэр, Сэргэлэн, Угтаал, Цээл, Эрдэнэсант зэрэг 19 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Баянчандмань, Жаргалант, Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод зэрэг 6 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Заамар зэрэг нийт 2 сум байна.

#### ***Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:***

Сумдад эхний 07 сарын байдлаар нийт 55850.9 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

#### ***Салбараа авч үзвэл:***

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 24647,96 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Эрүүл мэндийн сайдын багцаас 5622,8 сая төгрөгийг олгосон.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 368,4 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 333,8 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна. Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 19228,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон

**Өр, авлагын талаар:**

2020 оны 7-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгуулагууд нийт 198740,6 мянган төгрөгийн авлага, 211116,0 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 22724,3 мянган төгрөг нь түлш, халаалтын зардлын өглөг, 25610,6 мянган төгрөг нь цалингийн өглөг, 20626,9 мянган төгрөг нь НДШимтгэлийн өр, 5567,1 мянган төгрөг нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 55821,2 мянган төгрөг нь эмийн зардлын өглөг, үлдсэн 80765,9 мянган төгрөг нь бусад өр эзэлж байна.

**Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:**

**1. ХШҮ-ний чиглэлээр:**

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын үнэлгээний аргачлалаар “Хөгжлийн түүчээ- Төв аймаг -2024” болон “Аймгийн засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2020 оны эхний хагас жилийн байдлаар үнэлэн 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн ИТХ-аар оруулахаар өргөн бариад байна.

“Хөгжлийн түүчээ – Төв аймаг 2024” хэтийн зорилт 103 зорилтын 203 арга хэмжээний хүрээнд 88.24% - тай үнэлсэн бөгөөд 2019 оны 8 дугаар сартай харьцуулахад 19.32 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

**“Хөгжлийн түүчээ-төв аймаг”-2024**

**Хэтийн зорилтын I үе шатны хэрэгжилтийн явц**

№	Салбар	Зорилтын тоо	Заалтын тоо	Хэрэгжилт /хувиар/				Үнэлэх боломжгүй	Тухайн жилийн гүйцэтгэл	Оноо
				Үр дүнтэй 100% /90-100/	Тодорхой үр дүнд хүрсэн 70 % /60-89/	Эрчимжүүлэх шаардлагатай 40% /31-59/	Үр дүнгүй 0% /0-30/			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	<b>Эдийн засгийн тогтвортой хөгжил</b>	58	101	60	30	8	-	3	85.92%	4.31
1	Эдийн засгийн бодлого	9	9	9	-	-	-	-	100%	5
2	Хөдөө аж ахуйн салбар	23	37	29	7	1	-	-	92.7%	4.64
3	Аж үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын салбар	8	27	13	10	3	-	1	81.54%	4.08
4	Дэд бүтцийн салбар	18	28	9	13	4	-	2	75.77%	3.79
	<b>Байгаль орчны тогтвортой хөгжил</b>	7	23	12	8	3	-	-	81.74%	4.09
	<b>Нийгмийн тогтвортой хөгжил</b>	14	42	33	9	-	-	-	95.57%	4.68
1	Эрүүл мэндийн салбар	4	15	13	2	-	-	-	96%	4.8
2	Боловсрол, соёл, урлаг, спортын салбар	5	13	9	4	-	-	-	90.77%	4.54
3	Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал	5	14	11	3	-	-	-	93.57%	4.68
	<b>Тогтвортой хөгжлийн засаглал</b>	24	37	28	7	1	-	1	92.5%	4.63
	<b>ДҮН</b>	1	2	133	54	12	-	4	88.24%	4.41

		0	0						
		3	3						

“Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт” 2020 оны хасаг жилийн байдлаар 212 зорилтын 378 арга хэмжээг 95.53% - тай үнэллээ.

**Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

№	Салбар	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт /хувиар/				Үнэлэх боломжгүй	Тухайн жилийн гүйцэтгэл	Оноо
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлага тай	Үр дүнг үй			
				100 % /90-100/	70 % /60-89/	40% /31-59/	0% /0-30/			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	10	32	31	1	-	-	-	99.06%	4.95
2	Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого	30	94	87	7	-	-	-	97.77%	4.89
3	Дэд бүтэц, төв суурингийн хөгжлийг хангах бодлого	14	51	37	13	1	-	-	91.18%	4,56
4	Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого	11	34	25	7	2	-	-	90.29%	4.51
5	Нийгмийн хөгжлийн бодлого	24	101	83	17	-	-	-	94.9%	4.75
6	Нутгийн удирдлага, хууль хяналтын салбар	23	66	60	5	-	-	1	97.69%	4.88
НИЙТ		112	378	323	50	3	0	2	95.53%	4.78

**Найм. Цэргийн штабын хүрээнд:**

2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Монгол цэргийн Нэгдсэн холбоотой хамтран Төв аймаг дахь салбар холбоогоо байгууллалаа. Салбар хорооны тэргүүнээр аймгийн Засаг даргын орлогч Д.Мөнхбаатар, салбар холбооны нарийн бичгээр бэлтгэл дэд хурандаа Д.Очирбат томилж, батламж, тугийг гардуулж өглөө. Арга хэмжээнд Төв аймгийн удирдлагууд, Монгол улсын Ерөнхий сайдын зөвлөх, Монгол цэргийн Нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, дэслэгч генерал Ц.Тогоо, Монгол улсын Ерөнхий сайдын зөвлөх, Монгол цэргийн Нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Л.Алтангэрэл тэргүүтэй Монгол цэргийн Нэгдсэн холбооны төлөөлөл, Төв аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлага, бие бүрэлдэхүүн, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч нар оролцсон юм. Уг арга хэмжээний дараа ажлын хэсгийнхэн Монгол улсын баатар Дуламдоржийн Самдангийн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүллээ.

Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Хил хамгаалах Ерөнхий газартай хамтран хил хамгаалах байгууллагад алба хаах хүсэлтэй залуусыг гэрээт хилчний албанд элсүүлэх өдөрлөгийг 2020 оны 08 дугаар сарын 24-ний зохион явууллаа. Өдөрлөгийн үеэр гэрээт хилчнээр ажиллах сонирхолтой залуусд мэдээлэл өгч, гарын авлага тараан ажилласан. Өдөрлөгт Төрийн албан хаагчид болон Зуунмод сумын цэргийн алба хаасан 18-31 насны 20 гаруй залуус оролцож, 4 иргэн гэрээт хилчнээр ажиллахаар бүртгүүлээ.

“Хөгжлийн түүчээ-Төв аймаг”-2024 хөгжлийн бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, мэдээлэл, үр дүнг 4 жилээр нь нэгтэн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 08 дугаар сарын 27-ны өдөр гаргаж өглөө.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар